

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ /2019-2021 ОН/

АУДИТЫН КОД: АГГ-2022/22-ШТА-ГА

Улиастай сум 2022 он



Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа  
Утас: 7046-3612, Цахим хаяг: [bat-undraad@audit.gov.mn](mailto:bat-undraad@audit.gov.mn)  
Аудитын менежер Б.Дагвасүрэн  
Утас: 7046-3783, Цахим хаяг: [dagvasurenb@audit.gov.mn](mailto:dagvasurenb@audit.gov.mn)  
Аудитор Г.Чулуунбаатар  
Утас: 9908-4581, Цахим хаяг: [chuluunbaatar@audit.gov.mn](mailto:chuluunbaatar@audit.gov.mn)  
Аудитор Ц.Оюунсүвд  
Утас: 9907-6038, Цахим хаяг: [oyunsuvdts@audit.gov.mn](mailto:oyunsuvdts@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

## **АГУУЛГА**

|                                                                                                                                                                                 |              |
|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--------------|
| Товчилсон үгийн жагсаалт, хүснэгтэн мэдээллийн жагсаалт.....                                                                                                                    | 3            |
| Аудитын зорилго, хамарсан хүрээ, шалгуур үзүүлэлт, стандарт, арга зүй, үндсэн мэдээлэл.....                                                                                     | 4-6          |
| <b>БҮЛЭГ 1. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО ҮР ДҮНТЭЙ БАЙНА УУ?</b>                                            |              |
| 1.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин бүрдсэн үү?.....                                                   | 7-11         |
| 1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнтэй хэрэгжиж байна уу?..... | 12-18        |
| <b>БҮЛЭГ 2. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР АШИГТАЙ БАЙНА УУ?</b>                                                         |              |
| 2.1. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөж, хянаж, баталсан уу?.....                                      | 19-21        |
| 2.2. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орлого бүрдүүлэлт зорилтот түвшиндээ хүрсэн үү?.....                                                  | 22-24        |
| 2.3. Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа зорилтот түвшнийг хангаж, үр ашигтай байна уу?.....                                     | 24           |
| 2.4 Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагаа зардал үр ашгийн зохистой харьцааг хангаж байна уу?...25                      |              |
| <b>БҮЛЭГ 3. ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙНА УУ?</b>                                                               |              |
| 3.1 Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна уу?.....                                                                                                                               | 25-25        |
| 3.2 Дотоод хяналтын тогтолцоо оновчтой, хяналт үр нөлөөтэй байна уу?.....                                                                                                       | 25-25        |
| 3.3 Мэдээллийн иж бүрэн, үнэн зөв, ил тод байдлыг хангаж байна уу?.....                                                                                                         | 25-25        |
| <b>АУДИТЫН ДҮН, ДҮГНЭЛТ .....</b>                                                                                                                                               | <b>26-28</b> |
| <b>ЗӨВЛӨМЖ .....</b>                                                                                                                                                            | <b>29-31</b> |
| <b>ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН АЛБАН ТООТ .....</b>                                                                                                                       | <b>32-35</b> |
| <b>АУДИТ БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ .....</b>                                                                                                                                       | <b>36</b>    |
| <b>ХАВСРАЛТУУД .....</b>                                                                                                                                                        | <b>37-45</b> |

### ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| <b>Товчлол</b> | <b>Тайлал</b>                                               |
|----------------|-------------------------------------------------------------|
| ЗГ             | Засгийн газар                                               |
| УИХ            | Улсын Их Хурал                                              |
| ҮАГ            | Үндэсний аудитын газар                                      |
| МУЕА           | Монгол Улсын Ерөнхий аудитор                                |
| АГГ            | Аудитын гуравдугаар газар                                   |
| ШТА            | Шууд тайлагнах ажил                                         |
| ГА             | Гүйцэтгэлийн аудит                                          |
| ИТХ            | Иргэдийн төлөөлөгчдийн хурал                                |
| ИТХТ           | Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид                  |
| ЗДТГ           | Засаг даргын Тамгын газар                                   |
| МХГ            | Мэргэжлийн хяналтын газар                                   |
| БОГ            | Байгал орчны газар                                          |
| ОНӨААТҮГ       | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар      |
| ХХК            | Хязгаарлагдмал хариуцлагатай компани                        |
| ТУЗ            | Төлөөлөн Удирдах зөвлөл                                     |
| АДБОУС         | Аудитын дээд байгууллагын Олон Улсын стандарт               |
| УСНББОУС       | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт |
| НББОУС         | Нягтлан бодох бүртгэлийн Олон Улсын стандарт                |
| ЦУНС           | Цэвэр усны насос станц                                      |
| БУНС           | Бохир усны насос станц                                      |
| ААНОАТ         | Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар                       |
| ХХОАТ          | Хувь хүний орлогын албан татвар                             |
| НӨАТ           | Нэмэгдсэн өртгийн албан татвар                              |
| ХБГ            | Хүлээгдэж буй гүйцэтгэл                                     |

### ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ-1  
ХҮСНЭГТ-2  
ХҮСНЭГТ-3  
ХҮСНЭГТ-4  
ХҮСНЭГТ-5  
ХҮСНЭГТ-6  
ХҮСНЭГТ-7  
ХҮСНЭГТ-8  
ХҮСНЭГТ-9  
ХҮСНЭГТ-10  
ХҮСНЭГТ-11  
ХҮСНЭГТ-12

## **Аудит хийх үндэслэл, бүрэн эрх**

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийж, гүйцэтгэлээ.

## **Аудитын зорилго**

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэгдсэн болно.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. Үүнд:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх;

## **Аудитын хамарсан хүрээ**

Аудитад “Амь-Ус” ХХК-ийн 2019-2021 оны үйл ажиллагааны хүрээнд удирдлага, бүтэц зохион байгуулалт, санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн ашиглалт, дотоод хяналт, Төсвийн хөрөнгийн зарцуулалт болон холбогдох баримт материалыг хамруулав.

Аудитын явцад “Амь-Ус” ХХК-иас ирүүлсэн судалгаа, ТУЗ-ийн болон гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр, ажлын баримт, холбогдох албан тушаалтантай ярилцлага явуулсны дүнд ерөнхий эрсдэлийг “Дунд” гэж үзлээ.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн дагуу хэрэгжүүлсэн горим, сорилыг үнэлж тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

## **Аудитын арга зүй**

Аудитыг гүйцэтгэхдээ гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МУЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал” зэргийг баримтлан аудитад хамрагдсан байгууллага болон холбоотой талуудаас гаргуулсан баримт, мэдээлэл, тайланг судалж, нотлох зүйлсийг шалгуур үзүүлэлттэй харьцуулан нягтлан шалгах, харьцуулалт, дүн шинжилгээ хийх арга зүйг ашиглалаа.

## **Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд**

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын тухай хууль

- Монгол Улсын Засгийн Газрын тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Компанийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн албаны тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Татварын ерөнхий хууль
- Усны тухай хууль
- УИХ-ын 2006 оны 45, 2016 оны 19, 45, 2020 оны 23, 24, 52 дугаар тогтоолууд
- ЗГ-ын 2011 оны 69, 311, 2016 оны 80, 91, 121, 2018 оны 140, 2019 оны 290 дүгээр тогтоолууд
- Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162, 2016 оны 34 дүгээр тогтоолууд
- УСНББОУС, НББОУС болон бусад стандартууд
- ТУЗ-ийн тогтоол болон бусад тогтоол шийдвэрүүд
- Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн тогтоол, шийдвэр
- “Амь-Ус” ХХК-ийн дүрэм
- Бусад хууль, эрх зүйн актууд

### **Аудитын багийн бүрэлдэхүүн, хугацаа**

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа удирдаж, аудитын менежер Б.Дагвасүрэн үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, батлагдсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу аудитор Г.Чулуунбаатар, Ц.Оюунсүвд нар 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

### **Аудитыг гүйцэтгэхэд тулгарсан хүндрэл бэрхшээл**

Тус байгууллагын гүйцэтгэх захирал 2021 онд томилогдсон тул аудит хамрах хугацаа буюу 2019, 2020 онд ажиллаагүй, эдийн засагч нь аудит хамрах хугацаанд 3 солигдсон, үндсэн эдийн засагч нь жирэмсний амралттай байсан нь мэдээлэл авахад хүндрэлтэй, аудитын хугацаанд ҮАГ-аас зохион байгуулсан бүсийн сургалтад хамрагдах, манай байгууллагаас аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэстэй хамтарч зохион байгуулсан аймгийн төсвийн байгууллагын санхүүгийн ажилтны зөвлөгөөн болон төрийн хяналтын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойд зориулсан баримтат киноны зураг авалтад тус тус оролцсоноор аудит хийх хугацаа богино байсан, аудитор Ц.Оюунсүвд нь аудитын тайлагналын үе шатанд биеийн эрүүл мэндийн байдлаас шалтгаалж эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байгаа зэрэг хүндрэл бэрхшээлүүд байсан.

## **Ерөнхий мэдээлэл**

Завхан аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний байгууллага буюу одоогийн “Амь-Ус” ХХК нь анх 1930 онд Халуун ус нэртэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба 1940 оноос үйлдвэрийн холбоо, үйлдвэрлэлийн хоршооллын холбоо, 1972 оноос Нийтийн аж ахуй үйлчилгээний газар, 1987 оноос Завхан аймгийн Ахуйн үйлчилгээний удирдах газар, 1990 оноос Ус суваг ашиглалтын “Чандмань” компани, 1998 оноос “Ёст тохой” ХХК, 2001 оноос “Амь-Ус” ХХК, 2018 оноос “Амь-Ус” трейд ОНӨААТҮГ, 2021 оноос “Амь-Ус” ХХК нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Завхан аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор “Амь-Ус” трейд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг “Амь-Ус” хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчилсөн байна.

Компанийн эрхэм зорилго: Хэрэглэгчдийг унд ахуйн стандарт, шаардлагад нийцсэн усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, байгаль экологид нөлөөлөлгүйгээр цэвэршүүлж ажиллахад оршино.

Дээрх зорилгын хүрээнд дараах үндсэн үйл ажиллагааг эрхэлж байна. Үүнд:

- Цэвэр усаар хангах /төвлөрсөн усан хангамж/
- Бохир ус татан зайлуулах /ариутгах татуурга/
- Зөөврийн усан хангамж /22 ус түгээх байр/
- Нийтийн халуун усны үйлчилгээ /халуун ус, саун/
- Авто аж ахуйн үйлчилгээ /шугам сүлжээ, барилга угсралтын ажил/

Тус компани нь 2021 оны байдлаар 225 аж ахуйн нэгж, байгууллага, ... нийтийн орон сууц, ... хувийн орон сууцны 1,025 айл өрхийг төвлөрсөн шугам сүлжээгээр жилд 277,560 м3 унд ахуйн цэвэр усаар хангаж, нийт өрхийн 88.3 хувь буюу гэр хорооллын айл өрхөд 1 гүний худаг, 18ш ус түгээх байр, 2ш автомашинаар цэвэр ус зөөвөрлөн 36,210 м3 ус түгээсэн байна.

Компанийн эдийн засгийн үзүүлэлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1 /мян.төг/

| Үзүүлэлт/он | Нийт орлого | Нийт зарлага | Ашиг/алдагдал |
|-------------|-------------|--------------|---------------|
| 2019        | 731,551.0   | 825,355.4    | -93,804.4     |
| 2020        | 633,402.0   | 804,671.9    | -171,269.9    |
| 2021        | 1,232,264.0 | 954,122.8    | 278,141.2     |

**БҮЛЭГ 1: Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой компанийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн өндөр чадамжтай ТУЗ болон удирдлага дутмаг байна.**

**1.1. “Амь-Ус” ХХК-ийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна.**

**1.1.1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хуулиуд нь төрийн орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуй нэгжүүдийн чиг үүргийг өөрчлөх, хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангаж байна.**

Завхан аймгийн Нийтийн аж ахуй үйлчилгээний байгууллага буюу одоогийн “Амь-Ус” ХХК нь анх 1930 онд Халуун ус нэртэйгээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн ба 1940 оноос үйлдвэрийн холбоо, үйлдвэрлэлийн хоршооллын холбоо, 1972 оноос Нийтийн аж ахуй үйлчилгээний газар, 1987 оноос Завхан аймгийн Ахуйн үйлчилгээний удирдах газар, 1990 оноос Ус суваг ашиглалтын “Чандмань” компани, 1998 оноос “Ёст тохой” ХХК, 2001 оноос “Амь-Ус” ХХК, 2018 оноос “Амь-Ус” трейд ОНӨААТҮГ-аар 2020 оныг дуустал ажилласан.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор “Амь-Ус” трейд орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг “Амь-Ус” хязгаарлагдмал хариуцлагатай компани болгон өөрчилсөн байна.

Аймгийн ИТХ-ын хуралдааны 2021 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор Компанийн дүрмийг шинэчлэн баталж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 1,397,000.0 мянган төгрөгөөр тогтоожээ.

“Амь-Ус” ХХК нь Компанийн тухай хууль болон компанийн засаглалын кодексийн хүрээнд байгууллагын дүрмийг боловсруулж, ТУЗ, гүйцэтгэх удирдлага гэсэн бүтэцтэй байхаар тусгасан байна. ТУЗ-ийг 5 гишүүнтэй байгуулсан бөгөөд хараат бус гишүүн байна. Мөн ТУЗ нь даргатай байна. Даргыг нь ТУЗ-ийн саналыг үндэслэн Аймгийн Засаг дарга томилж чөлөөлнө гэжээ.

ТУЗ нь компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн орлого, зарлага, зохион байгуулалтын бүтэц, орон тоо, удирдлагын зардлын дээд хязгаарыг батлах эрхтэй байна.

“Амь-Ус” ХХК-ийн нэрийг аймгийн ИТХ-ын хуралдааны тогтоолоор өөрчлөн баталж байгаа нь зөвхөн нэршлийн хувьд өөрчилж байгаа хэдий ч тус компанийн үйл ажиллагааг тогтворжуулах Монгол Засгийн Газраас гаргаж байгаа бодлого шийдвэрүүдтэй уялдуулжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, холбогдох бусад хуулиуд компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг хангаж байгаа бөгөөд ТУЗ болон компанийн удирдлага нь яаж ажиллахаас шалтгаалж байна.

**1.1.2. Өмнөх онуудаас уламжлан хийж ирсэн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилтуудыг хангуулан ажиллаж ирсэн ч хийсэн ажлын үр дүн, явц, хэрэгжилт зэргийг хянаж үнэлгээ өгсөн талаар тайлан тэмдэглэл байхгүй, хяналт тавих дотоод хяналтын комисс нь тодорхой хийсэн ажил байхгүй байна.**

“Амь-Ус” ХХК-ийн дүрмийн 1.7.1-д компанийн үйл ажиллагааны чиглэлүүдийг тусгасан нь:

- ✓ Хүн ам, байгууллага, аж ахуйн нэгжийн усны хэрэгцээг унд ахуйн стандарт, шаардлагад тохирсон цэвэр усаар байнга, тасралтгүй хангах
- ✓ Хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, байгаль экологид нөлөөлөлгүйгээр цэвэршүүлж ажиллах
- ✓ Нийтийн аж ахуйн барилга байгууламж, шугам сүлжээ, техник тоног төхөөрөмжийн ашиглалт, засвар шинэчлэлт хийх, шинэ техник тоног төхөөрөмж нэвтрүүлэх, үйлдвэрлэл үйлчилгээний чанарыг сайжруулах, нэр төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээг авах
- ✓ Нийтийн халуун усны үйлчилгээ /халуун ус, саун/-г хариуцах
- ✓ Авто аж ахуйн үйлчилгээ /шугам сүлжээ, барилга угсралтын ажил/ хийх
- ✓ Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны эрхийн асуудлыг чандлан сахиж, ажиллагсдын нийгмийн асуудлыг анхаарч ажиллах үндсэн чиг үүргүүдийг тусган хэрэгжүүлж байна.

Дээрх чиг үүргүүдийг хэрэгжүүлэх 2019-2021 онуудын төлөвлөгөөг гарган ТУЗ-өөр батлуулсан ч 2019 оны үйл ажиллагааны тайлангийн хэрэгжилтийг хамт олны хурлаар хэлэлцүүлж, үр дүнг ТУЗ-ийн хурлаар оруулан үр дүнг тооцсон ч 2020-2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцүүлээгүй байна.

Өмнөх онуудаас уламжлан хийж ирсэн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилтуудыг хангуулан ажиллаж ирсэн ч хийсэн ажлын үр дүн, явц хэрэгжилт зэргийг хянаж үнэлгээ өгсөн талаар тайлан тэмдэглэл байхгүй, хяналт тавих дотоод хяналтын комисс нь тодорхой хийсэн ажил байхгүй байна.

**1.2. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнтэй хэрэгжихэд ТУЗ-ийн үр нөлөө бага, байгууллагын удирдлага болон мэргэжлээрээ олон жил ажилласан сайн баг ажилтнуудын хамтын үйл ажиллагаа сайнаар нөлөөлж байна.**

**1.2.1. Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнтэй хэрэгжихэд ТУЗ-ийн үр нөлөө бага байна.**

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2.1. “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ашигт ажиллагаа, засаглал, өмч хувьчлалын бодлогыг сайжруулж, төр, хувийн хэвшлийн түншлэлийг шинэ шатанд гаргана”, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4.10. “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно” гэж тус тус тусгасан байна.

Энэ зорилтын хүрээнд 2019-2021 оны байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөнд баруун аймгуудын Нийтийн аж ахуйн байгууллагуудтай хамтран ажиллаж туршлага солилцох, уралдаант арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар тусгуулан хэрэгжүүлсэн байна.

Мөн дэлхийн усны аян зохион байгуулах, салбар байгууллагуудтай хамтран ажиллах болон ЦУНС 2-р өргөлтөд их засвар хийх, ЦУНС 1-р өргөлтийг камержуулах, хайс хамгаалалтыг засварлах, БУНС-ын халаалтын системийг

шинэчлэх, засварлах, гүний насосын штангель трубаг солих зэрэг шинэчлэлтийн ажлуудыг хийж өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах шинэчлэх ажлуудыг хийсэн байна.

2019 онд цэвэр усны нөөцийг үр ашигтай зарцуулах, шугам сүлжээний алдагдлыг бууруулах, арилгах зорилгоор цэвэр усны төв болон салбар шугамын үзлэгийг хийж холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, 30 байгууллагыг тоолууржуулах, айл өрхийн болон цэвэр усны шугамын 780 гэмтэл засварлаж хэвийн байдалд оруулжээ. ЦУНС 2-р өргөлтөд их засвар хийж, цэвэрлэх байгууламжийн анхны дамжлага болох септикийн урд эгнээний 500м<sup>3</sup> лаг гарган зайлуулж, ажиллах нөхцөлийг сайжруулжээ.

Аймгийн МХГ болон Ус, цаг уур, орчны шинжилгээний лабораториудтай хамтран ажиллах гэрээ байгуулан лаборатори хоорондын харьцуулалтын шинжилгээг хийж хэвшжээ.

2020-2021 онуудад байгууллагын төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг гүйцэтгэсэн бөгөөд хамтын гэрээнд заасны дагуу тээврийн хэрэгслүүдийн бүрэн бүтэн байдлыг хангуулан засвар үйлчилгээг тогтмол хийлгэж, усны аюулгүй байдлын төлөвлөгөөний баг хамтран Улиастай сумын усан хангамжийн эх үүсвэрт халдваргүйжүүлэх төхөөрөмж тавихаар шийдвэрлүүлжээ. Мөн “Цэвэр ус -2020” аяныг зарлаж аянаар нуувар ус хэрэглэгч нарыг илрүүлэн нөхөн бичилт хийж тоолууржуулж ажилласан нь үр дүнгээ өгсөн байна.

“Амь-Ус” ХХК нь Компанийн үйл ажиллагааны хувьд өөрийн байгууллагын санхүүгийн нөөц боломжид тулгуурлан орон нутгийн өмчийн хадгалалт хамгаалалт, ашиглалтыг сайжруулан их болон урсгал засваруудыг хийж үйлдвэрлэлийн үйл ажиллагааг тасралтгүй жигд удирдаж байна.

Засгийн газрын 2016-2020, 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан төрийн болон орон нутгийн өмчийн засаглалыг сайжруулах зорилт үр дүнтэй хэрэгжихэд ТУЗ-ийн үр нөлөө бага, байгууллагын удирдлага болон мэргэжлээрээ олон жил ажилласан сайн баг ажилтнуудын хамтын үйл ажиллагаа сайнаар нөлөөлж байна.

**1.2.2. “Амь-Ус” ХХК-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ТУЗ нь тогтворгүй, компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, үйл ажиллагааг хараат бус байдлаар дүгнэх, эрсдэлээс хамгаалах, ашигт ажиллагааны түвшнийг үнэлэх зэрэгт нөлөөгүй байна.**

“Амь-Ус” ХХК нь компанийн үйл ажиллагааны хувьд Аймгийн ИТХ-ын 2016 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн 52 тоот тогтоол, 2018 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 22 тоот тогтоолуудаар ТУЗ-ийг байгуулж байсныг хүчингүйд тооцож, аймгийн ИТХТ-ийн 2020 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 47 тоот тогтоолоор ТУЗ-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан ч энэ тогтоолыг хүчингүйд тооцож, 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 26 тоот тогтоолоор компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн баталжээ.

Дээрх байдлаас дүгнэхэд “Амь-Ус” ХХК-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ТУЗ нь тогтворгүй, улс төрийн шалтгааны улмаас солигдон өөрчлөгдөж байна. Энэ нь тус Компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, үйл ажиллагааг хараат бус

байдлаар дүгнэх, эрсдэлээс хамгаалах, ашигт ажиллагааны түвшнийг үнэлэх зэрэгт нөлөөлж ТУЗ-ийн эрх, үүргийг хэрэгжүүлж чадахгүйд хүргэж байна.

**1.2.3. ТУЗ-ийн гишүүд нь компанийн ашигт ажиллагааг сайжруулах, дотоод хяналтыг үр ашигтай зохион байгуулах талаар бодитой санал, санаачилга гаргаж ажиллаагүй, ТУЗ-ийн бодлого, шийдвэр үр нөлөө байхгүй байна.**

“Амь-Ус” ХХК-ийн хувьцаа эзэмшигч нь аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал /Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид/ хуульд заасан хугацаанд 2020 он, 2021 онд ТУЗ-ийг шинэчлэн батлах тухай 2 удаа хуралджээ.

“Амь-Ус” ХХК-ийн ТУЗ нь 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд компанийн дүрмийн 6.2-т Төлөөлөн удирдах зөвлөл нь 5 гишүүнтэй байх бөгөөд хараат бус гишүүн байна гэж заажээ.

2019-2021 онуудын тайлан материалаас дүгнэхэд ТУЗ нь баримталж ажиллах “Орон нутгийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг батлуулан мөрдөж ажиллаагүй байна. ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.8, 79 дүгээр зүйлийн 79.1.3, 79.1.4-д заасан шалгуурыг тус тус хангахгүй байна.

ТУЗ нь холбогдох хууль тогтоомж, компанийн дүрэмд заасан эрх хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор 2019 онд 5 тогтоол, 2020 онд 3 тогтоол, 2021 онд 2 тогтоол гаргасан байна.

Дээрх тогтоолууд нь:

- ❖ Компанийн орон тоо, цалингийн сангийн төсөв, үйл ажиллагааны төлөвлөгөө батлах тухай
- ❖ Орлого, зарлагын төсөв батлах тухай
- ❖ Тайлан дүгнэх, ашиг хуваарилах тухай
- ❖ Шатахууны лимит тогтоох тухай тогтоолууд гарсан бөгөөд 2020-2021 онд эхний 2 асуудлыг баталснаас өөр тогтоол гаргаагүй байна.

ТУЗ-ийн гишүүд нь компанийн ашигт ажиллагааг сайжруулах, дотоод хяналтыг үр ашигтай зохион байгуулах талаар бодитой санал, санаачилга гаргаж ажиллаагүй, үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн дүрэм, журам, заавар хөтөлбөр боловсруулан батлуулж ажиллаагүй байна.

Тус онуудад ТУЗ ажилласан ажлын тайлан, тэмдэглэл байхгүй, тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй, ТУЗ-ийн бодлого, шийдвэр үр нөлөө байхгүй, нэр төдий байна.

**БҮЛЭГ 2: “Амь-Ус” ХХК-ийн 2019-2020 оны орлого төвлөрүүлэлт дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлаас шалтгаалан 4.1-21.5 хувиар тасарсан ч, 2021 оны орлого 31.9 хувиар давж зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн байна.**

**2.1. “Амь-Ус” ХХК-ийн жилд хийх ажлын төлөвлөгөө, тухайн жилд төвлөрүүлэх орлого, гарах зардлын төлөвлөгөө болон хүрэх түвшний асуудлуудыг хянуулаагүй батлуулсан байна.**

**2.1.1. Эдийн засгийн зорилтот түвшний үзүүлэлтүүдийг тооцож төлөвлөхдөө өмнөх оны батлагдсан төлөвлөгөө болон ХБГ-ийг үндэслэсэн бөгөөд тухайн**

жилд гарах эдийн засгийн бусад орлого, зарлагад нөлөөлөх хүчин зүйлүүд, бараа материал үнийн хэлбэлзлийг судалж тооцоо судалгаа гарган төлөвлөөгүй байна.

| Эдийн засгийн үндсэн үзүүлэлт | Төлөвлөгөө       |                  |                  |
|-------------------------------|------------------|------------------|------------------|
|                               | 2019 он          | 2020 он          | 2021 он          |
| <b>Нийт орлого</b>            | <b>762,943.0</b> | <b>806,560.0</b> | <b>934,177.0</b> |
| Усан хангамж                  | 610,150.0        | 644,060.0        | 774,323.0        |
| Зөөврийн усан хангамж         | 52,793.0         | 47,500.0         | 59,854.0         |
| Бусад орлого                  | 100,000.0        | 115,000.0        | 100,000.0        |
| <b>Нийт зардал</b>            | <b>754,688.5</b> | <b>805,584.1</b> | <b>933,356.8</b> |
| Үүнээс Удирдлагын зардал      | 171,030.6        | 174,916.4        | 160,800.0        |
| Татварын өмнөх ашиг/алдагдал/ | 8,254.5          | 975.9            | 820.2            |
| Цэвэр ашиг /алдагдал/         | 7,429.0          | 878.3            | 738.2            |
| Нийт ажиллагсдын тоо          | 56               | 55               | 57               |
| Нийт цалингийн сан            | 361,032.1        | 409,082.6        | 495,256.8        |
| Нэг ажилтны дундаж цалин      | 537.2            | 619.8            | 724.0            |

Тус байгууллага жил жилийн эдийн засгийн үзүүлэлтүүдийн зорилтот түвшнийг төлөвлөхдөө өмнөх жилийн батлагдсан төлөвлөгөө, хүлээгдэж байгаа гүйцэтгэлийг үндэслэн төлөвлөсөн байна. Үүнд:

❖ Орлогын төлөвлөлтийг авч үзвэл /мян.төг/

2019 оны орлогыг төлөвлөхдөө 2018 оны төлөвлөгөөнөөс 74.5 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өсгөж, ХБГ-ээс 49.3 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар доогуур тооцож төлөвлөсөн нь үндсэн үйл ажиллагаанаас орох орлогыг тогтмол байх хэмжээнд төлөвлөжээ.

| д/д | Орлогын үзүүлэлт      | 2018 оны<br>төлөвлөгөө | 2018 оны<br>гүйцэтгэл | 2019 оны<br>төлөвлөгөө |
|-----|-----------------------|------------------------|-----------------------|------------------------|
| 1   | Усан хангамж          | 595,316.6              | 586,143.6             | 610,150.0              |
| 2   | Зөөврийн усан хангамж | 51,108.0               | 51,136.9              | 52,793.0               |
| 3   | Бусад                 | 42,000.0               | 175,039.5             | 100,000.0              |
|     | <b>Дүн</b>            | <b>688,424.6</b>       | <b>812,320.0</b>      | <b>762,943.0</b>       |

2020 оны орлогыг төлөвлөхдөө 2019 оны төлөвлөгөөнөөс 43.6 мянган төгрөгөөр буюу 0.5 хувиар өсгөж, ХБГ-ээс 75.0 мянган төгрөгөөр буюу 10.0 хувиар өсгөн төлөвлөсөн нь үндсэн үйл ажиллагаанаас орох орлого 2019 оны ХБ гүйцэтгэлээр орлого 31.4 мянган төгрөгөөр тасарч, нэмэгдүүлж байгаа тооцоолол гарч байгаа хэдий ч өмнөх онтой орлогын өсөлтийг ижил төлөвлөжээ.

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”**

| д/д | Орлогын үзүүлэлт      | 2019 оны<br>төлөвлөгөө | 2019 оны<br>гүйцэтгэл | 2020 оны<br>төлөвлөгөө |
|-----|-----------------------|------------------------|-----------------------|------------------------|
| 1   | Усан хангамж          | 610,150.0              | 619,392.0             | 644,060.0              |
| 2   | Зөөврийн усан хангамж | 52,793.0               | 47,159.0              | 47,500.0               |
| 3   | Бусад                 | 100,000.0              | 65,000.0              | 115,000.0              |
|     | <b>Дүн</b>            | <b>762,943.0</b>       | <b>731,551.0</b>      | <b>806,560.0</b>       |

2021 оны орлогыг төлөвлөхдөө 2020 оны төлөвлөгөөнөөс 127.6 мянган төгрөгөөр буюу 15 хувиар өсгөж, ХБГ-ээс 300.8 мянган төгрөгөөр буюу 47.4%-иар өсгөн төлөвлөсөн нь үндсэн үйл ажиллагаанаас орох орлого 2019 оны ХБГ-ээрх орлого 173.1 мянган төгрөгөөр тасарч гарсан дүн нэмэгдүүлж байгаа тооцоолол гарч байгаа хэдий ч өмнөх онтой орлогын өсөлтийг ижил төлөвлөжээ.

| д/д | Орлогын үзүүлэлт      | 2020 оны<br>төлөвлөгөө | 2020 оны<br>гүйцэтгэл | 2021 оны<br>төлөвлөгөө |
|-----|-----------------------|------------------------|-----------------------|------------------------|
| 1   | Усан хангамж          | 644,060.0              | 579,023.0             | 774,323.0              |
| 2   | Зөөврийн усан хангамж | 47,500.0               | 54,379.0              | 59,854.0               |
| 3   | Бусад                 | 115,000.0              | -                     | 100,000.0              |
|     | <b>Дүн</b>            | <b>806,560.0</b>       | <b>633,402.0</b>      | <b>934,177.0</b>       |

Орлогыг өснө гэж төлөвлөсөн гол шалтгаан нь орон сууц, аж ахуйн нэгжүүдийн тоо өссөн болон төсөвт байгууллагуудын үйл ажиллагаа жигдэрч ирсэн нь нөлөөлсөн.

Зарлагыг төлөвлөхдөө 2019 онд 8,245.5 мянган төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай гарахаар, 2020-2021 онд 975.0-820.2 мянган төгрөгийн ашигтай гарахаар баталсан нь нийт зардалд эзлэх цалингийн зардлын өсөлт нөлөөлсөн байгаа бөгөөд захиргаа удирдлагын зардлыг тогтмол хэмжээнд бусад зардлыг 1.4 хувиар өсгөж төлөвлөсөн байна.

| д/д | Үзүүлэлт                             | 2019 оны<br>төлөвлөгөө | 2020 оны<br>төлөвлөгөө | 2021 оны<br>төлөвлөгөө |
|-----|--------------------------------------|------------------------|------------------------|------------------------|
| 1   | Цалингийн зардал                     | 361,032.1              | 409,082.6              | 433,349.8              |
| 2   | Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | 41,518.0               | 51,801.5               | 61,907.0               |
| 3   | Цахилгааны зардал                    | 50,100.0               | 50,200.0               | 60,150.0               |
| 4   | Шатахууны зардал                     | 46,000.0               | 48,000.0               | 48,000.0               |
| 5   | Түлээ нүүрсний зардал                | 4,500.0                | 4,200.0                | 6,500.0                |
| 6   | Түүхий эд, материалын зардал         | 15,000.0               | 32,000.0               | 45,000.0               |
| 7   | Машин тоног төхөөрөмжийн зардал      | -                      | -                      | -                      |
| 8   | Сэлбэг хэрэгслийн зардал             | 6,000.0                | 9,000.0                | 9,000.0                |
| 9   | Хөдөлмөр хамгааллын зардал           | 4,500.0                | 3,500.0                | 12,700.0               |
| 10  | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал    | 82,000.0               | 83,000.0               | 91,000.0               |
| 11  | Албан томилолтын зардал              | 8,200.0                | 4,500.0                | 4,500.0                |
| 12  | Холбоо, бичиг хэргийн зардал         | 5,900.0                | 3,000.0                | 3,000.0                |
| 13  | Тээврийн зардал                      | 3,400.0                | 2,500.0                | 2,000.0                |
| 14  | Зар сурталчилгааны зардал            | 500.0                  | 2,000.0                | 1,000.0                |
| 15  | Шагнал урамшууллын зардал            | 1,500.0                | -                      | 500.0                  |
| 16  | Тэтгэмжийн зардал                    | 3,800.0                | 4,500.0                | 18,000.0               |
| 17  | Сургалт, семинарын зардал            | 4,000.0                | 3,000.0                | 2,000.0                |
| 18  | Найдваргүй авлагын зардал            | 3,500.0                | 2,000.0                | 2,000.0                |

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”**

|            |                                            |                  |                  |                  |
|------------|--------------------------------------------|------------------|------------------|------------------|
| 19         | Ус ашигласны төлбөр                        | 1,200.0          | 1,200.0          | 2,500.0          |
| 20         | Үндсэн хөрөнгийн татвар                    | 1,550.0          | 1,650.0          | 2,500.0          |
| 21         | Газрын төлбөр                              | 2,300.0          | 1,500.0          | 1,300.0          |
| 22         | Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо      | 400.0            | 650.0            | 650.0            |
| 23         | Нийгмийн зардал /хоол/                     | 21,000.0         | 20,000.0         | 8,000.0          |
| 24         | Засвар үйлчилгээний зардал                 | 9,000.0          | 9,000.0          | 45,000.0         |
| 25         | ТУЗ-ийн зардал                             | 8,416.0          | 3,100.0          | 3,100.0          |
| 26         | Ажлын хөлс                                 | 7,000.0          | 11,500.0         | 11,500.0         |
| 27         | Усны шинжилгээний зардал                   | 2,400.0          | 2,000.0          | 2,000.0          |
| 28         | Бусад зардал                               | 12,150.0         | 7,500.0          | 7,500.0          |
| 29         | Халаалтын зардал                           | 23,000.0         | 19,000.0         | 32,000.0         |
| 30         | Даатгалын зардал                           | 3,100.0          | 2,500.0          | 2,500.0          |
| 31         | Лабораторийн зардал                        | 1,300.0          | 1,500.0          | 2,000.0          |
| 32         | Усны зохицуулах зөвлөлийн                  | 3,422.4          | 3,950.0          | 3,950.0          |
| 33         | Эрүүл мэндийн үзлэгийн зардал              | 700.0            | 450.0            | 450.0            |
| 34         | С/шугамын тулгуур багануудад хагалбар хийх | 8,300.0          | 4,800.0          | 4,800.0          |
| 35         | Урсгал засвар                              | 8,000.0          | 3,000.0          | 3,000.0          |
| <b>Дүн</b> |                                            | <b>754,688.5</b> | <b>805,584.1</b> | <b>933,356.8</b> |

Эдийн засгийн зорилтот түвшний эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцож төлөвлөхдөө өмнөх оны батлагдсан төлөвлөгөө болон ХБГ-ийг үндэслэсэн бөгөөд тухайн жилд гарах эдийн засгийн болон бусад орлого, зарлагад нөлөөлөх хүчин зүйлүүд, бараа материал үнийн хэлбэлзлийг судалж тооцоо судалгаа гарган төлөвлөөгүй байна.

**2.1.2. “Амь-Ус” ХХК-ийн жилд хийх ажлын төлөвлөгөө, тухайн жилд төвлөрүүлэх орлого, гарах зардлын төлөвлөгөөг болон хүрэх түвшний асуудлуудыг хянасан эрх бүхий байгууллага байхгүй байна.**

Тус компанийн удирдлага, санхүүгийн ажилтан нь байгууллагын жилд хийх ажлын төлөвлөгөө болон тухайн жилд төвлөрүүлэх орлого, гарах зардлын төлөвлөгөөг гарган ТУЗ-д оруулан жил бүр батлуулсан боловч тоон үзүүлэлтүүд, хүрэх түвшний асуудлуудыг хянасан дүн шинжилгээ хийсэн хяналтын тайлан, хянасан эрх бүхий байгууллага гишүүн байхгүй байна.

**2.1.3. “Амь-Ус” ХХК-ийн 2019-2021 онуудын эдийн засгийн зорилтот түвшнийг ТУЗ-өөр батлуулан ажиллажээ.**

“Амь-Ус” ХХК-ийн 2019-2021 онуудын жилийн ажлын төлөвлөгөө, тухайн жилд төвлөрүүлэх орлого, гарах зардлын төлөвлөгөөг ТУЗ-ийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 01 тоот тогтоолоор, 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01 тоот тогтоолоор, 2021 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 01 тоот тогтоолуудаар тус тус батлуулжээ.

**2.2. “Амь-Ус” ХХК-ийн 2019-2020 оны орлого төвлөрүүлэлт дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлаас шалтгаалан 4.1-21.5 хувиар тасарсан ч, 2021 оны орлого 31.9 хувиар давж зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн байна.**

**2.2.1. “Амь-Ус” ХХК-нь 2021 онд төлөвлөсөн орлогоо 131.9 хувиар давуулан төвлөрүүлжээ.**

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”**

Хүснэгтээр харуулбал: мян/төг

| Үзүүлэлт              | 2019 оны төлөвлөгөө | 2019 оны гүйцэтгэл | Зөрүү             | Хувь         |
|-----------------------|---------------------|--------------------|-------------------|--------------|
| Усан хангамж          | 610,150.0           | 619,392.0          | 9,242.0           | 101.5        |
| Зөөврийн усан хангамж | 52,793.0            | 47,159.0           | -5,634.0          | 89.3         |
| Бусад орлого          | 100,000.0           | 65,000.0           | -35,000.0         | 65.0         |
| <b>Дүн</b>            | <b>762,943.0</b>    | <b>731,551.0</b>   | <b>-31,392.0</b>  | <b>95.9</b>  |
| Үзүүлэлт              | 2020 оны төлөвлөгөө | 2020 оны гүйцэтгэл | Зөрүү             | Хувь         |
| Усан хангамж          | 644,060.0           | 579,023.0          | -65,037.0         | 89.9         |
| Зөөврийн усан хангамж | 47,500.0            | 54,379.0           | 6,879.0           | 114.5        |
| Бусад орлого          | 115,000.0           | -                  | -115,000.0        | 0.0          |
| <b>Дүн</b>            | <b>806,560.0</b>    | <b>633,402.0</b>   | <b>-171,269.0</b> | <b>78.5</b>  |
| Үзүүлэлт              | 2021 оны төлөвлөгөө | 2021 оны гүйцэтгэл | Зөрүү             | Хувь         |
| Усан хангамж          | 774,323.0           | 1,124,584.0        | 350,261.0         | 145.2        |
| Зөөврийн усан хангамж | 59,854.0            | 53,680.0           | -6,174.0          | 89.7         |
| Бусад орлого          | 100,000.0           | 54,000.0           | -46,000.0         | 54.0         |
| <b>Дүн</b>            | <b>934,177.0</b>    | <b>1,232,264.0</b> | <b>298,087.0</b>  | <b>131.9</b> |

Хүснэгтээс харахад 2019-2020 оны орлого төвлөрүүлэлт дэлхий нийтийг хамарсан “Ковид-19” цар тахлаас шалтгаалан 4.1-21.5 хувиар тасарсан, 2021 оны орлого 31.9 хувиар давж зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн байна.

2020 онд 633,402.0 мянган төгрөгийн цэвэр борлуулалттай ажиллаж 171,269.0 мянган төгрөгийн алдагдалтай үйл ажиллагаа явуулж өмнөх оноос нийт орлого 98,100.0 мянган төгрөгөөр буурсан, алдагдал 17,129.0 мянган төгрөгөөр өссөн байна. Орлого дутуу төвлөрөх гол шалтгаан нь “Ковид-19” цар тахлын улмаас аж ахуй нэгж болон төсөвт байгууллагууд үйл ажиллагаагаа зогсоосон болон хэвийн явагдаагүй нь борлуулалтын орлогод нөлөөлжээ.

2021 онд 1,232,264.0 мянган төгрөгийн цэвэр борлуулалттай ажиллаж, орлого 131,900.0 мянган төгрөгөөр давсан нь тус онд төсөвт байгууллагуудын 1м3 усны үнэ тарифыг /3,000-4,500/ 1,500 төгрөгөөр нэмэгдүүлсэн, аж ахуй нэгж байгууллагууд хэвийн горимд шилжин ажилласан нь нөлөөлсөн байна.

“Амь-Ус” ХХК нь 2021 онд төлөвлөсөн орлогоо 31.9 хувиар давуулан төвлөрүүлжээ.

## **2.2.2. Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийн тооцоог бүрэн хийж төвлөрүүлэн үлдэгдлийг тооцож байна.**

“Амь-Ус” ХХК нь 2019-2021 онуудад ногдуулсан улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр, хураамжийг төвлөрүүлсэн бөгөөд 2021 оны эцэст 56,950.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тооцоо нийлсэн актуудаар баталгаажуулсан байна.

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”**

2019-2021 оны татваруудын ногдуулалт /мян.төг/

| Татвар<br>төлбөр<br>хураамжи<br>йн нэр | ААНОАТ<br>ногдол | ААНОАТ<br>үлдэгдэл | ХХОАТ<br>ногдол | ХХОАТ<br>үлдэгдэл | Ус<br>ашигласны<br>татвар<br>ногдол | Ус<br>ашигласны<br>татвар<br>үлдэгдэл | Бусад<br>татвар<br>ногдол | Бусад<br>татвар<br>үлдэгдэл | НДШ<br>ногдол | НДШ<br>үлдэгдэл |
|----------------------------------------|------------------|--------------------|-----------------|-------------------|-------------------------------------|---------------------------------------|---------------------------|-----------------------------|---------------|-----------------|
| 2019                                   | 8,033.93         | 5,988.45           | 24,998.3        | 1,001.29          | 3,459.28                            | 3,459.28                              | 3,163.8                   | 992.23                      | 91,872.86     | 0               |
| 2020                                   | 8,033.93         | 0                  | 66,441.95       | 19,670.47         | 3,459.28                            | 2,484.58                              | 6,853.62                  | 1,235.64                    | 101,560.46    | 13,116.27       |
| 2021                                   | 27,754.27        | 25,952.55          | 65,440.66       | 4,669.96          | 47,042.28                           | 1,245.96                              | 8,293.53                  | 3,604.93                    | 113,653.18    | 0               |

Хүснэгтээр татварын үлдэгдлийг харуулбал: /мян.төг/

| Татвар, төлбөр,<br>хураамжийн нэр | ААНОАТ    | НӨАТ      | ХХОАТ     | Ус ашигласны<br>татвар | Бусад<br>татвар | НДШ       | Нийт дүн         |
|-----------------------------------|-----------|-----------|-----------|------------------------|-----------------|-----------|------------------|
| 2019                              | 5,988.45  | 10,522.32 | 1,001.29  | 3,459.28               | 992.23          | 0.00      | <b>21,963.60</b> |
| 2020                              | 0.00      | 45,196.27 | 19,670.47 | 2,484.58               | 1,235.64        | 13,116.27 | <b>81,703.25</b> |
| 2021                              | 25,952.55 | 21,477.22 | 4,669.58  | 1,245.96               | 3,604.93        | 0.00      | <b>56,950.27</b> |

**2.3. 2021 оноос үндсэн үйл ажиллагаа жигдэрч 250.3 сая төгрөгийн ашигтай ажиллаж, зорилтот түвшнийг хангаж, үр ашигтай ажиллаж эхэлжээ.**

**2.3.1. Үр ашгийн тооцооллууд хийхдээ тухайн жилд гарах эдийн засгийн болон бусад орлого, зарлагад нөлөөлөх хүчин зүйлүүд, бараа материал үнийн хэлбэлзлийг судалж тооцоо судалгаа гарган төлөвлөөгүй байна.**

“Амь-Ус” ХХК-ийн эдийн засгийн зорилтот түвшний эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцож төлөвлөхдөө өмнөх оны батлагдсан төлөвлөгөө болон ХБГ-ийг үндэслэсэн бөгөөд тухайн жилд гарах эдийн засгийн болон бусад орлого, зарлагад нөлөөлөх хүчин зүйлүүд, бараа материал үнийн хэлбэлзлийг судалж тооцоо судалгаа гарган төлөвлөөгүй байна.

“Амь-Ус” ХХК-ийн тухайн жилд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг үйлдвэрлэл, техникийн ажилчид болон хүний нөөцийн ажилтнууд асуудлуудаа дэвшүүлэн гаргаж хэлэлцэж гаргадаг бөгөөд тус байгууллагын 1м3-ийн усны үнэ 2021 оноос өмнө өөрчлөгдөөгүй тогтвортой байсан тул орлогын төлөвлөгөөг боловсруулахад гол нөлөө үзүүлэх үзүүлэлт болдог байна.

Орлого, зарлагын үр ашгийн тооцооллууд болон төлөвлөгөөнд дүн шинжилгээ хийсэн харьцуулсан судалгаа байхгүй бөгөөд батлагдсан үзүүлэлтүүд нь өсөлт, бууралтын хэлбэлзэл багатай харьцангуй бодитой хийгдсэн гэж үзэх үндэстэй байна.

**Үйл ажиллагааны харьцаа үзүүлэлт:** Байгууллагын бараа материалын үлдэгдэл 107,414.4 мянган төгрөг, үндсэн хөрөнгийн нөөц боломжтой, үр ашгийн үр өгөөж сайн гарч байна. Харин авлага 102,393.1 мянган төгрөг байгаа нь төлөгдөх найдвартай авлага байна гэж үзлээ.

**Хөрвөх чадварын харьцаа үзүүлэлт:** Богино хугацаат 53,345.3 мянган төгрөгийн өрийг төлөх чадвартай эрсдэл багатай, бэлэн мөнгөний хомсдол үүсэхгүй эрсдэл бага үзүүлэлт гарч байна.

**Өр төлбөрийн харьцаа:** Нийт хөрөнгийн дүнд эзлэх урт хугацаат 1,304,445.6 мянган төгрөгийн өр төлбөр балансад байгаа бөгөөд насжилтийн хувьд урт, төлөгдөх найдвар бага, өр төлөх чадвар эрсдэл багатай байна. Энэ өрийг яаж барагдуулах талаар холбогдох эрх бүхий байгууллагуудтай ярилцаж шийдвэрлэх нь зүйтэй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгсөн, хэрэгжих шатандаа байна. Энэ өр нь тус байгууллагын үйл ажиллагаатай холбоотой үүссэн урт хугацааны өр биш байна.

**2.3.2. ТУЗ нь санхүүгийн тайлангаарх зөвхөн ашиг алдагдал, орлого, зардлыг авч үзэж байгаа нь үр нөлөө бага, үйлдвэрлэлээс гарах алдагдлыг бууруулах, гарах үр өгөөж, үр нөлөөг тооцоогүй байна.**

Байгууллагын тухайн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, орон тоо бүтэц, орлого, зарлагын төлөвлөгөөний биелэлт, жилийн эцсийн үр дүнг ТУЗ-өөр жил бүр оруулан дүгнүүлдэг бөгөөд хэлэлцсэн асуудлуудыг ажиглаж үзэхэд үндсэн үйл ажиллагаа болон үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг онцолж авч үзсэн байна. Тухайлбал: Борлуулсан бүтээгдэхүүний өртгийг зөв ангилах, захиргаа удирдлагын зардлыг хэмнэх, зөөврийн ус түгээх ажлыг тасралтгүй явуулах, шугамын алдагдлыг дэлгэрэнгүй гаргаж хянах, зөөврийн усны алдагдлыг бууруулах талаар саналуудыг ярилцсан тэмдэглэл байгаа бөгөөд яагаад алдагдал гарч байгаа талаар тооцоо судалгаа оруулаагүй хэт ерөнхий асуудлуудад хандсан байна.

Дээрх байдлаас дүгнэхэд жилийн ажлын төлөвлөгөөний биелэлтийг нарийвчилж гарган биелэлтийг асуудал нэг бүрээр оруулан дүгнээгүй, үндсэн үйлдвэрлэлтэй холбоотой асуудлыг хэт ерөнхий оруулсан, өмнөх онуудтай харьцуулсан орлого, зардлыг судлаагүй, зөвхөн 1м3-ийн тарифыг өсгөснөөр орлого өссөн ч бусад эх үүсвэрүүдийг судалж үзсэн тооцоо байхгүй, орлого нэмэгдэх боломжуудыг судалж үзээгүй, нөгөө талаас зөөврийн усны алдагдлыг бууруулах талаар тооцоо судалгаа байхгүй, яагаад юунд байгаа шалтгааныг тодруулаагүй байна.

Тухайлбал зөөврийн ус болон ус түгээх байруудын орлого зардлыг нарийвчлан оруулж хэлэлцүүлээгүй нөхцөл байдал шалтгааныг тогтоогоогүй байна.

Дээрх онуудаас 2021 оны аймгийн төсөвт байгууллагуудын цэвэр усны бичилтийг тулган шалгахад дараах зөрчил илэрч байна.

Хот, суурин ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлийн 2020 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 105 дугаар тогтоолоор Завхан аймгийн Улиастай сумын төсөвт байгууллагад мөрдөх цэвэр, бохир усны үйлчилгээний тарифыг шинэчлэн тогтоож өгсөн байна.

Гэтэл тус компани дээрх тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй, өөрчлөгдсөн шийдвэрээ төсөвт байгууллагуудад хүргүүлээгүй, албан байгууллагыг алагчилж зарим газар нэмэгдүүлэн бичилт хийж зарим газрын усны үнийг нэмэгдүүлээгүй зөрчил илэрлээ.

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”**

Мөн цэвэр бохир усны бичилтийг хийхдээ сар бүр тогтмол бичилт хийдэггүй, сар алгасдаг, зарим байгууллагын бичилтийг 2-8 сар хүртэл бичээгүй зөрчил илэрч байна. Үүнд:

| Д/д | он сар                                          | 2021.01<br>сар             | 2021.02<br>сар             | 2021.03<br>сар             | 2021.04<br>сар             | 2021.05<br>сар             | 2021.06<br>сар             | 2021.07<br>сар             | 2021.08<br>сар             | 2021.09<br>сар             | 2021.10<br>сар             | 2021.11<br>сар             | 2021.12<br>сар             |
|-----|-------------------------------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|----------------------------|
|     | Төсөвт байгууллагын<br>нэр                      | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 | цэвэр,<br>бохир<br>усны м3 |
| 1   | Гэр бүл хүүхэд<br>залуучуудын хөгжлийн<br>газар | 38                         | 6                          | 16                         |                            | 14                         | 6                          |                            |                            | 28                         |                            | 32                         | 20                         |
| 2   | Богдын гол багийн төв                           | 8                          |                            | 22                         | 6                          | 4                          |                            |                            |                            | 12                         | 18                         |                            |                            |
| 3   | Ахмадын хороо                                   | 22                         | 14                         | 12                         |                            |                            |                            |                            | 34                         | 8                          | 28                         | 28                         | 14                         |
| 4   | Дөрвөн оноо ӨЭ                                  | 6                          |                            | 8                          |                            | 33                         |                            | 64                         |                            | 6                          |                            |                            | 18                         |
| 5   | 7-р цэцэрлэг                                    | 15                         | 41                         |                            | 86                         |                            |                            |                            |                            | 156                        | 26                         | 24                         | 138                        |
| 6   | 6-р цэцэрлэг                                    | 40                         | 86                         | 86                         | 86                         | 86                         |                            |                            |                            |                            | 190                        | 198                        | 196                        |
| 7   | 1-р цэцэрлэг                                    | 44                         | 142                        |                            |                            |                            |                            |                            | 102                        | 44                         | 50                         | 66                         | 220                        |
| 8   | Хөдөлмөр халамжийн<br>үйлчилгээний газар        | 338                        |                            |                            |                            | 136                        |                            | 24                         | 178                        | 10                         | 47                         | 210                        | 176                        |
| 9   | Номын сан                                       |                            | 24                         |                            |                            |                            | 11                         |                            | 7                          |                            |                            | 12                         |                            |
| 10  | 2-р сургууль                                    |                            | 242                        | 30                         |                            | 120                        | 242                        |                            | 192                        |                            | 94                         | 160                        | 181                        |
| 11  | 3-р цэцэрлэг                                    |                            | 52                         |                            | 60                         | 50                         |                            |                            |                            | 40                         | 40                         | 40                         | 171                        |
| 12  | Прокурор                                        |                            |                            | 90                         |                            | 84                         | 16                         |                            | 78                         | 34                         | 40                         | 74                         | 6                          |
| 13  | Стандарт хэмжил зүйн<br>хэлтэс                  |                            |                            |                            |                            |                            |                            |                            | 15                         |                            |                            | 4                          |                            |
| 14  | Мэргэжлийн хяналтын<br>газар                    |                            |                            |                            |                            |                            |                            |                            |                            |                            |                            |                            | 54                         |

**Цэвэр, бохир усны дутуу бичилттэй холбоотой давхардсан тоогоор 49 байгууллагын 78,076.2 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэлээ.**

ТУЗ нь санхүүгийн тайлангаарх зөвхөн ашиг алдагдал, орлого, зардлыг авч үзэж байгаа нь үр нөлөө бага, үйлдвэрлэлээс алдагдлыг бууруулах, гарах үр өгөөж, үр нөлөөг тооцоогүй байна.

**2.3.3. 2019-2021 онд их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий худалдан авалт, бусад гэрээ хийгдээгүй байна.**

Их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчил бүхий худалдан авалт, бусад гэрээ аудит хамрах хугацаанд хийгдээгүй байна.

**2.4. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг зөрчиж нэн шаардлагагүй автомашин дахин бэлтгэсэн байна.**

**2.4.1. “Амь-Ус” ХХК нь 2019-2021 онуудад Удирдлагын зардлыг оновчтой төлөвлөж, арвилан хэмнэлттэй зарцуулсан бөгөөд зардлыг бууруулах, хэмнэх бодлоготой ажиллажээ.**

Удирдлагын зардал нь нийт зардлын төлөвлөлтийг хийхдээ 2020 онд 3,885.8 мянган төгрөгөөр 2019 оны төлөвлөгөөнөөс өсгөж, 2021 онд 14,116.4 мянган төгрөгөөр бууруулж төлөвлөсөн байна.

Удирдлагын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл /мян.төг/

| д/д | Үзүүлэлт         | 2019 оны<br>төлөвлөгөө | 2019 оны<br>гүйцэтгэл | 2020 оны<br>төлөвлөгөө | 2020 оны<br>гүйцэтгэл | 2021 оны<br>төлөвлөгөө | 2021 оны<br>гүйцэтгэл |
|-----|------------------|------------------------|-----------------------|------------------------|-----------------------|------------------------|-----------------------|
|     | Захиргаа аж ахуй |                        |                       |                        |                       |                        |                       |

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”**

|                                |                                         |                  |                  |                  |                  |                  |                  |
|--------------------------------|-----------------------------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|------------------|
| 1                              | Цалингийн зардал                        | 112,076.6        | 129,416.2        | 117,776.4        | 124,418.1        | 125,000.0        | 135,614.1        |
| 2                              | Нийгмийн даатгалын<br>шимтгэлийн зардал | 12,888.0         |                  | 13,540.0         |                  | 9,300.0          | 3,026.4          |
| 3                              | Шатахууны зардал                        | 4,500.0          | 7,512.3          | 6,500.0          | 4,763.3          | 5,000.0          | 4,377.9          |
| 4                              | Түүхий эд, материалын<br>зардал         | 700.0            | 1,197.6          | 700.0            |                  | 700.0            |                  |
| 5                              | Сэлбэг хэрэгслийн<br>зардал             | 500.0            |                  | 3,000.0          |                  | 2,500.0          |                  |
| 6                              | Албан томилолтын<br>зардал              | 6,700.0          | 3,787.1          | 6,500.0          | 1,667.2          | 4,000.0          | 64.0             |
| 7                              | Холбоо, бичиг хэргийн<br>зардал         | 3,000.0          | 2,102.4          | 3,000.0          | 1,817.3          | 2,500.0          | 2,312.5          |
| 8                              | Цахилгааны зардал                       | 250.0            |                  | 1,300.0          |                  | 1,000.0          |                  |
| 9                              | Бусад зардал                            | 1,000.0          | 301.7            | 1,000.0          | 3,762.2          | 2,800.0          | 6,074.4          |
| 10                             | Халаалтын зардал                        | 8,750.0          | 8,640.1          | 7,500.0          | 2,727.3          | 6,500.0          | 4,040.1          |
| 11                             | Шагнал урамшууллын<br>зардал            | 2,500.0          |                  | 1,500.0          |                  | 1,000.0          |                  |
| 12                             | Хоолны зардал                           | 8,400.0          |                  | 4,500.0          |                  | -                | 728.0            |
| 13                             | Онгоцны зардал                          | 1,350.0          |                  | 600.0            |                  | 500.0            |                  |
| <b>Дүн</b>                     |                                         | <b>162,614.6</b> | <b>152,957.3</b> | <b>167,416.4</b> | <b>139,155.4</b> | <b>160,800.0</b> | <b>156,237.3</b> |
| <b>Төлөөлөн Удирдах зөвлөл</b> |                                         |                  |                  |                  |                  |                  |                  |
| 1                              | Цалингийн зардал                        | 7,100.0          | 4,068.0          | 6,500.0          | -                | -                | -                |
| 2                              | Нийгмийн даатгалын<br>шимтгэлийн зардал | 816.0            | 457.0            | 600.0            | -                | -                | -                |
| 3                              | Бусад зардал                            | 500.0            |                  | 400.0            | -                | -                | -                |
| <b>Дүн</b>                     |                                         | <b>8,416.0</b>   | <b>4,525.0</b>   | <b>7,500.0</b>   | <b>-</b>         | <b>-</b>         | <b>-</b>         |
| <b>Нийт дүн</b>                |                                         | <b>171,030.6</b> | <b>157,482.3</b> | <b>174,916.4</b> | <b>139,155.4</b> | <b>160,800.0</b> | <b>156,237.3</b> |

Харин гүйцэтгэлийг авч үзэхэд удирдлагын зардал баталсан төлөвлөгөөнөөс 2019 онд 13,548.3 мянган төгрөгөөр, 2020 онд 35,761.0 мянган төгрөгөөр, 2021 онд 4,562.7 мянган төгрөгөөр тус тус хэмнэлттэй зарцуулагджээ.

Удирдлагын зардал нийт үйл ажиллагааны зардлын 2019 онд 19.9 хувийг, 2020 онд 17.2 хувийг, 2021 онд 16.4 хувийг эзэлж байгаа нь удирдлагын зардлыг зөв төлөвлөсөн, хэмнэлттэй зарцуулсан байна гэж үзэж байна.

Удирдлагын зардал хэмнэгдсэн ч зарцуулалтаас ажиглалт хийхэд удирдлагын албан хэрэгцээнд унадаг автомашины шатахууны зардал хэтрэх эрсдэлтэй байгаад анхаарч ажиллах шаардлагатай байна.

#### **2.4.2. 2021 онд үйл ажиллагааны үр дүнгээр ашигтай гарсан ч дотоодын нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглаагүй байна.**

2020 онд нийт зардлыг 805,584.1 мянган төгрөгөөр төлөвлөсөн нь 2019 оны төлөвлөгөөнөөс 50,895.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлээс 12,702.4 мянган төгрөгөөр илүү төлөвлөсөн, 2021 онд зардлыг 2020 оны төлөвлөгөөнөөс 127,772.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлээс 128,684.9 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”**

**2019-2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл /мян.төг/**

| д/д | Үзүүлэлт                                   | 2019 оны<br>төлөвлөгөө | 2019 оны<br>гүйцэтгэл | 2020 оны<br>төлөвлөгөө | 2020 оны<br>гүйцэтгэл | 2021 оны<br>төлөвлөгөө | 2021 оны<br>гүйцэтгэл |
|-----|--------------------------------------------|------------------------|-----------------------|------------------------|-----------------------|------------------------|-----------------------|
| 1   | Цалингийн зардал                           | 361,032.1              | 371,460.8             | 409,082.6              | 408,182.5             | 433,349.8              | 441,094.9             |
| 2   | Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал       | 41,518.0               | 49,166.8              | 51,801.5               | 49,215.1              | 61,907.0               | 61,535.8              |
| 3   | Цахилгааны зардал                          | 50,100.0               | 57,176.9              | 50,200.0               | 59,335.9              | 60,150.0               | 24,136.1              |
| 4   | Шатахууны зардал                           | 46,000.0               | 54,689.7              | 48,000.0               | 38,032.9              | 48,000.0               | 36,880.2              |
| 5   | Түлээ нүүрсний зардал                      | 4,500.0                | 1,194.7               | 4,200.0                | 6,125.0               | 6,500.0                | 7,906.8               |
| 6   | Түүхий эд, материалын зардал               | 15,000.0               | 48,124.9              | 32,000.0               | 37,457.2              | 45,000.0               | 112,750.1             |
| 7   | Сэлбэг хэрэгслийн зардал                   | 6,000.0                | 16,262.7              | 9,000.0                | 5,974.6               | 9,000.0                | 10,866.6              |
| 8   | Хөдөлмөр хамгааллын зардал                 | 4,500.0                | 1,878.5               | 3,500.0                | 9,616.5               | 12,700.0               | 9,655.2               |
| 9   | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал          | 82,000.0               | 82,798.7              | 83,000.0               | 104,019.4             | 91,000.0               | 94,941.9              |
| 10  | Албан томилолтын зардал                    | 8,200.0                | 4,447.1               | 4,500.0                | 1,667.2               | 4,500.0                | 64.0                  |
| 11  | Холбоо, бичиг хэргийн зардал               | 5,900.0                | 5,607.8               | 3,000.0                | 5,364.1               | 3,000.0                | 5,850.2               |
| 12  | Тээврийн зардал                            | 3,400.0                | 1,641.0               | 2,500.0                | 1,071.6               | 2,000.0                | 3,519.5               |
| 13  | Зар сурталчилгааны зардал                  | 500.0                  | -                     | 2,000.0                | 200.0                 | 1,000.0                | -                     |
| 14  | Шагнал урамшууллын зардал                  | 1,500.0                | -                     | -                      | 397.9                 | 500.0                  | 18,549.5              |
| 15  | Тэтгэмжийн зардал                          | 3,800.0                | 6,534.2               | 4,500.0                | 7,857.4               | 18,000.0               | 22,977.3              |
| 16  | Сургалт, семинарын зардал                  | 4,000.0                | -                     | 3,000.0                | 250.0                 | 2,000.0                | 160.0                 |
| 17  | Найдваргүй авлагын зардал                  | 3,500.0                | 7,987.6               | 2,000.0                | -                     | 2,000.0                | -                     |
| 18  | Ус ашигласны төлбөр                        | 1,200.0                | -                     | 1,200.0                | -                     | 2,500.0                | -                     |
| 19  | Үл хөдлөх хөрөнгийн татвар                 | 1,550.0                | 1,858.9               | 1,650.0                | -                     | 2,500.0                | -                     |
| 20  | Газрын төлбөр                              | 2,300.0                | 1,200.0               | 1,500.0                | -                     | 1,300.0                | -                     |
| 21  | Тээврийн хэрэгслийн татвар, оношилгоо      | 400.0                  | 595.4                 | 650.0                  | -                     | 650.0                  | -                     |
| 22  | Нийгмийн зардал /хоол/                     | 21,000.0               | 20,142.7              | 20,000.0               | 7,893.6               | 8,000.0                | 728.0                 |
| 23  | Засвар үйлчилгээний зардал                 | 9,000.0                | 8,772.5               | 9,000.0                | -                     | 45,000.0               | 22,205.9              |
| 24  | ТУЗ-ийн зардал                             | 8,416.0                | 975.0                 | 3,100.0                | -                     | 3,100.0                | -                     |
| 25  | Ажлын хөлс                                 | 7,000.0                | 13,495.0              | 11,500.0               | 7,440.0               | 11,500.0               | 8,862.7               |
| 26  | Усны шинжилгээний зардал                   | 2,400.0                | -                     | 2,000.0                | -                     | 2,000.0                | -                     |
| 27  | Бусад зардал                               | 12,150.0               | 9,212.0               | 7,500.0                | 24,601.5              | 7,500.0                | 37,647.0              |
| 28  | Халаалтын зардал                           | 23,000.0               | 25,639.4              | 19,000.0               | 25,794.5              | 32,000.0               | 17,383.5              |
| 29  | Даатгалын зардал                           | 3,100.0                | 1,107.2               | 2,500.0                | 1,017.4               | 2,500.0                | 850.0                 |
| 30  | Лабораторийн зардал                        | 1,300.0                | -                     | 1,500.0                | -                     | 2,000.0                | -                     |
| 31  | Усны зохицуулах зөвлөлийн                  | 3,422.4                | -                     | 3,950.0                | -                     | 3,950.0                | -                     |
| 32  | Эрүүл мэндийн үзлэгийн зардал              | 700.0                  | -                     | 450.0                  | -                     | 450.0                  | -                     |
| 33  | С/шугамын тулгуур багануудад хагалбар хийх | 8,300.0                | -                     | 4,800.0                | 2,100.0               | 4,800.0                | -                     |
| 34  | Урсгал засвар                              | 8,000.0                | -                     | 3,000.0                | 1,057.5               | 3,000.0                | -                     |
| 35  | Түрээсийн зардал                           | -                      | -                     | -                      | -                     | -                      | 2,717.7               |

**“ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН  
ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ”**

|     |                        |           |           |           |           |           |           |
|-----|------------------------|-----------|-----------|-----------|-----------|-----------|-----------|
| 36  | Баяр ёслолын зардал    | -         | -         | -         | -         | -         | 6,542.9   |
| 37  | Ариун цэврийн зардал   | -         | -         | -         | -         | -         | 3,315.3   |
| 38  | Хүү, торгуулийн зардал | -         | -         | -         | -         | -         | 2,981.5   |
| Дүн |                        | 754,688.5 | 791,969.5 | 805,584.1 | 804,671.9 | 933,356.8 | 954,122.8 |

2020-2021 онуудын төлөвлөгөөг нэмэгдүүлэн баталсан гол шалтгаан нь ажилтнуудын цалингийн зардал өссөнтэй холбоотой байна. 2020-2021 оны гүйцэтгэлийг авч үзэхэд 2020 онд 912.2 мянган төгрөгийн хэмнэлттэй, 2021 онд 20,766.0 мянган төгрөгөөр зардал хэтрүүлсэн дүнтэй тайлагнагджээ. Түүхий эд материалын зардал 67,750.1 мянган төгрөгөөр, шагнал урамшууллын зардал 18,049.5 мянган төгрөгөөр тус тус хэтэрч бусад бараа үйлчилгээний зардал 74,514.7 мянган төгрөгөөр хэмнэгджээ.

Батлагдсан орон тоог судалж үзэхэд 2019 онд 56 орон тоо батлагдаж 52 орон тоотой, 2020 онд 55 орон тоо батлагдаж 52 орон тоо, 2021 онд 57 орон тоо батлагдаж 49 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулжээ. 2021 онд ухаалаг худаг ашиглалтад орсноор 8 орон тоог цөөлж ажилласан, цалингийн санг 3,360.0 мянган төгрөгөөр хэмнэж ажилтнуудын тэтгэмж урамшуулалд зарцуулсан байна.

Удирдлагын болон үйл ажиллагааны зарцуулалтын байдлыг хянахад зарцуулалтад тавих удирдлагын хяналт сул, харилцах дансанд байгаа мөнгийг байгууллагын үйл ажиллагааны зардалд шилжүүлэхдээ зөвхөн нягтлан бодогч интернэт банкаар гүйлгээ хийдэг, 2021 оныг авч үзэхэд 1,042,386.32 мянган төгрөгийн зөрчил илэрсэнд албан шаардлага өгөхөөр шийдвэрлэлээ.

**2.4.3. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг зөрчиж нэн шаардлагагүй автомашин дахин бэлтгэсэн байна.**

2019-2020 онд тус компани өөрийн хөрөнгөөр нийт 114,350.6 мянган төгрөгийн үндсэн болон үндсэн үйл ажиллагаатай холбоотой машин тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг төлөвлөгөөний дагуу худалдан авчээ. Үүнд:

- ✓ 2019 онд 53,895.4 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэснээс байгууллагын хэрэгцээ шаардлагыг үндэслэн 44,545.4 мянган төгрөгийн усны машин, 350.0 мянган төгрөгийн бичгийн ширээ, хэрэгцээ шаардлагыг судлаагүйгээр байгууллагын үйлчилгээний автомашин байхад Соната-6 суудлын автомашин 9,000.0 мянган төгрөгөөр тус тус худалдаж авсан.



- ✓ 2020 онд хэрэгцээ шаардлагыг үндэслэн 1 зөөврийн компьютер 2,727.2 мянган төгрөгөөр, 2 суурин компьютер 1,390.0 мянган төгрөгөөр;
- ✓ 2021 онд 56,337.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авснаас 10,814.0 мянган төгрөгийн фитнесийн тоног төхөөрөмж комоор нь байгууллагын ажилтнуудын ая тухтай орчныг бүрдүүлэх дасгал хөдөлгөөн хийх зориулалтаар хэрэгцээ шаардлагыг судалж авсан байна.
- ✓ 2019 онд үйлчилгээний автомашин худалдан авсан байхад нэн шаардлагагүй Соната-7 суудлын автомашиныг дахин 8,000.0 мянган төгрөгөөр худалдан авсан зөрчил илэрсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.4-д “энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх” гэсэн заалтыг зөрчсөн тул төлбөрийн акт тогтоож орон нутгийн орлогод оруулахаар шийдвэрлэлээ.



- ✓ Үндсэн үйл ажиллагаатай холбоотой 37,523.1 мянган төгрөгөөр цэвэр, бохирын насос болон мотор, туслах эд ангиудыг бэлтгэж зориулалтын дагуу бүрэн ашиглаж байна.

**БҮЛЭГ 3: “Амь-Ус” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналт, санхүүгийн хяналт үр нөлөөгөө өгсөн байна.**

**3.1. “Амь-Ус” ХХК-ийн үйл ажиллагааны үр дүн болон санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн хөндлөнгийн хяналтын үр нөлөө, үр дүнтэй байна.**

**3.1.1. Санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж үр нөлөөтэй байна.**

“Амь-Ус” ХХК-ийн 2019-2021 оны үйл ажиллагаанд Төрийн аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийгдээгүй бөгөөд тус онуудад санхүүгийн тайлангийн аудит хийгдэж “Зөрчилгүй” санал дүгнэлтийг авсан байна.

2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар 58,822.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч 58,322.7 мянган төгрөгийн зөрчилд 4 заалт бүхий зөвлөмж, 500.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоогдож, биелэлтийг 100% хангуулсан байна.

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн зарцуулалт болон бүртгэл хөтлөлттэй холбоотой алдаа зөрчил илрээгүй байна.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар 1,402,548.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн бөгөөд урт хугацааны 1,304,445.6 мянган төгрөгийн өрийг барагдуулах, хөдөлгөөнд оруулах, 98,102.8 мянган төгрөгийн зөрчил нь бүртгэл хөтлөлт, хөрөнгө худалдан авахтай холбоотой илэрсэн зөрчлийг засаж ажиллах чиглэлээр 4 заалт бүхий зөвлөмж өгөгдөж хэрэгжих шатандаа байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар тус байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт үр дүн, төсвийн зарцуулалт, хүний нөөцийн бодлого бусад үйл ажиллагааг хамруулан горим сорил хэрэгжүүлэн ажиллаж зөвлөмж, дүгнэлтийг өгсөн нь үр нөлөөтэй байна.

**3.1.2. Санхүүгийн хяналт, аудитын албанаас санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт үр нөлөөтэй, 2 жил тутамд шалгаж зөвлөмж өгч үр дүнг тооцож байна.**

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь төсвийн болон орон нутгийн өмчит газруудын санхүүгийн үйл ажиллагааг хоёр жил тутамд хамруулан графикаар шалгадаг бөгөөд “Амь-Ус” ХХК-ийн 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, зарцуулалтад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийжээ.

Тус хяналт шалгалтаар үндсэн үйл ажиллагааны шатахууны зарцуулалт болон ажилчдын цалингаас суутгалыг дутуу хийсэн зэрэгтэй холбоотой 1,722.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, орон нутгийн төсөвт нөхөн төлбөр тогтоосон бөгөөд 100 хувийн хэрэгжилттэй байна.

**3.2. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналт нэр төдий, эрсдэлийн удирдлагаар хангах нөхцөл бүрдээгүй хяналт үр нөлөөгүй байна.**

**3.2.1. ТУЗ-өөс тус байгууллагын үйл ажиллагааны үр дүн явц, санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах мэргэжлийн болон хууль, эрх зүйн чадамж болон нөхцөл бүрдээгүй хяналтын чиглэлээр үр нөлөө байхгүй байна.**

“Амь-Ус” ХХК-ийн ТУЗ нь 5 гишүүнтэй байхаар дүрмээ баталсан тул ТУЗ-ийн дэргэд ямар нэгэн хяналт, хороо байхгүй байна.

**3.2.2. Гүйцэтгэх удирдлагын дэргэд дотоод хяналт нэр төдий, эрсдэлийн удирдлагаар хангах нөхцөл бүрдээгүй байна.**

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу “аж ахуйн нэгж байгууллага бүр өөрийн онцлогт тохирсон чадварлаг хараат бус дотоод хяналтын нэгж байгуулан ажиллана” гэж заасны дагуу “Амь-Ус” ХХК-ийн захирлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн Б/45 дугаар тушаалаар дотоод хяналтын комиссыг шинэчлэн 3 хүний бүрэлдэхүүнтэй томилсон байна.

Дээрх комисс нь дотоод хяналт шалгалтыг хэрэгжүүлэх жилийн төлөвлөгөө боловсруулан батлуулсан байна. Хяналтын төлөвлөгөөг шалгахад ихэвчлэн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явц, дотоод ажил, шилэн дансны хяналтыг хийхээр 7 ажил тусгасан байна.

Хяналт шалгалтыг хийсэн талаар нягтлахад 1 удаа хяналт хийсэн 1 хуудас тайлан байх боловч тайлан нь шаардлага хангаагүй, хяналт хийсэн ажлаа тодорхой бичээгүй байна.

Дээрх байдлаас дүгнэхэд гүйцэтгэх удирдлагын дэргэд дотоод хяналт нэр төдий, эрсдэлийн удирдлагаар хангах нөхцөл бүрдээгүй байна.

**3.3. “Амь-Ус” ХХК-ийн мэдээ, мэдээлэл нь хоорондоо харилцан уялдаатай ил тод байдлыг хангаж байна.**

**3.3.1. Төрийн байгууллагуудын мэдээ, мэдээлэл нь хоорондоо харилцан уялдаатай байна.**

Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөлд өвөлжилтийн бэлтгэл ажлын мэдээ тайлан, тоолуурын судалгаа, санхүүгийн мэдээллүүдийг өгөхөөс гадна Хяргас нуур Завхан голын сав газрын захиргаанд бохирдуулагч аж ахуй нэгжүүдийн судалгааг, аймгийн МХГ, БОГ-т цэвэр, бохир усны шинжилгээний хариуг, Стандарт хэмжил зүйн төв, аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэс, Татварын хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэст санхүүгийн сар, улирал, жилийн татвар, төлбөр хураамжийн мэдээ судалгааг тус тус гаргаж хүргүүлдэг бөгөөд Төрийн аудитын газар, Санхүүгийн хяналт, аудитын алба зэрэг хяналтын байгууллагуудын өгсөн зөвлөмж, албан шаардлагын биелэлтийг хангуулахад хамтарч ажиллаж байна. Дээрх мэдээ, мэдээллүүд нь хоорондоо харилцан уялдаатай байна.

**3.3.2. “Амь-Ус” ХХК-ийн мэдээлэл ил тод, нээлттэй байж, иргэдийг мэдээллээр хангаж байна.**

Шилэн дансны тухай хуулийн 3 зугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-д хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-д тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх үүрэгтэй. Дээрх заалтуудын дагуу “Амь-Ус” ХХК-ийн 2021 оны ажил гүйлгээг тулган шалгахад тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 148 мэдээллээс 143 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн, хугацаа хоцроож 5 мэдээллийг мэдээлсэн байна.

Байгууллагын ил тодын самбар дээр санхүүгийн мэдээллийг сар, улирал, жилээр, дотоод журам, хамтын гэрээ, ээлжийн график хуваарь, үйлчилгээний үнэ тарифын жагсаалт зэргийг гаргаж мэдээлсэн байна.

Аудитаар нийт 1,128,462.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илрүүлж, 8,000.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор, 78,076.2 мянган төгрөгийн зөрчилд ... заалт бүхий зөвлөмж өгөхөөр, 1,042,386.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

## **АУДИТЫН ДҮГНЭЛТ**

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. “Амь-Ус” ХХК-ийн засаглалыг хөгжүүлэх хууль, эрх зүйн орчин хангалттай бүрдээгүй байна;
2. Өмнөх онуудаас уламжлан хийж ирсэн үйл ажиллагааны үндсэн чиглэл, зорилтуудыг хангуулан ажиллаж ирсэн ч хийсэн ажлын үр дүн, явц хэрэгжилтийг хянаж үнэлгээ өгсөн талаар тайлан тэмдэглэл байхгүй, хяналт тавих дотоод хяналтын комисс нь тодорхой хийсэн ажил байхгүй байна;
3. “Амь-Ус” ХХК-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх ТУЗ нь тогтворгүй, компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, үйл ажиллагааг хараат бус байдлаар дүгнэх, эрсдэлээс хамгаалах, ашигт ажиллагааны түвшнийг үнэлэх зэрэгт нөлөөгүй байна;
4. ТУЗ-ийн гишүүд нь компанийн ашигт ажиллагааг сайжруулах, дотоод хяналтыг үр ашигтай зохион байгуулах талаар бодитой санал, санаачилга гаргаж ажиллаагүй, ТУЗ бодлого, шийдвэрт үр нөлөө үзүүлэхээргүй ажиллаж байна;
5. Эдийн засгийн зорилтот түвшний эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцож төлөвлөхдөө өмнөх оны батлагдсан төлөвлөгөө болон ХБГ-ийг л үндэслэсэн бөгөөд тухайн жилд гарах эдийн засгийн болон бусад орлого, зарлагад нөлөөлөх хүчин зүйлүүд, бараа материал үнийн хэлбэлзлийг судалж тооцоо судалгаа гарган төлөвлөөгүй байна;
6. “Амь-Ус” ХХК-ийн жилд хийх ажлын төлөвлөгөө, тухайн жилд төвлөрүүлэх орлого, гарах зардлын төлөвлөгөө болон хүрэх түвшний асуудлуудыг хянасан эрх бүхий байгууллага байхгүй байна;
7. Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолыг зөрчиж нэн шаардлагагүй автомашин дахин бэлтгэсэн байна;
8. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналт нэр төдий, эрсдэлийн удирдлагаар хангах нөхцөл бүрдээгүй хяналт үр нөлөөгүй байна;
9. Цэвэр, бохир усны бичилтийг хийхдээ сар бүр тогтмол бичилт хийдэггүй, сар алгасдаг, зарим байгууллагын бичилтийг 2-8 сар хүртэл бичээгүй зөрчил илэрч байна;
10. 2021 онд үйл ажиллагааны үр дүнгээр ашигтай гарсан ч дотоодын нөөц боломжийг бүрэн дүүрэн ашиглаагүй, он дамжсан 1,304.4 сая төгрөгийн өрийг барагдуулах талаар ажил зохион байгуулаагүй байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА

## **ЗӨВЛӨМЖ**

### **Төлөөлөн Удирдах зөвлөлийн дарга Г.Нармандах-д**

1. “Амь-Ус” ХХК-ийн жилд хийх ажлын төлөвлөгөө болон тухайн жилд төвлөрүүлэх орлого, гарах зардлын төлөвлөгөөг нарийвчлан хэлэлцэж, тухайн жилд хүрэх түвшний асуудлуудыг тоо болон чанарын үзүүлэлтүүдээр баталж өгч байх;
2. ТУЗ-ийн гишүүд нь компанийн ашигт ажиллагааг сайжруулах, дотоод хяналтыг үр ашигтай зохион байгуулах талаар бодитой санал, санаачилга гаргаж ажиллах;
3. ТУЗ нь бодлого, шийдвэрт үр нөлөөтэй ажиллах;
4. “Амь-Ус” ХХК-ийн жилд хийх ажлын төлөвлөгөө болон тухайн жилд төвлөрүүлэх орлого, гарах зардлын гүйцэтгэлийн хүрэх түвшний асуудлуудыг хянаж, дүн шинжилгээ хийх, дотоод хяналтыг тодорхой болгож ажиллах.

### **“Амь-Ус” ХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Мягмардорж-д**

1. Компанийн эдийн засгийн зорилтот түвшний эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцож төлөвлөхдөө өмнөх оны батлагдсан төлөвлөгөө, ХБГ-ээс гадна тухайн жилд гарах эдийн засгийн болон бусад орлого, зарлагад нөлөөлөх хүчин зүйлүүд, бараа материал үнийн хэлбэлзлийг судалж, тооцоо судалгааны үндсэн дээр төлөвлөж байх;
2. “Амь-Ус” ХХК-ийн жилд хийх ажлын төлөвлөгөө болон тухайн жилд төвлөрүүлэх орлого, гарах зардлын төлөвлөгөөг болон хүрэх түвшний асуудлуудыг эрх бүхий байгууллагаар хянуулж батлуулах;
3. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналтыг санхүүгийн болон хууль, эрх зүйн мэдлэгтэй, удирдлага болон байгууллагыг эрсдэлийн удирдлагаар хангах ажилтнуудыг томилон ажиллуулах;
4. Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж Засгийн газрын 2021 оны 388 дугаар тогтоолыг мөрдлөг болгон ажиллах;
5. Цэвэр, бохир усны үнэ тариф, төсвийн газар болон айл өрхүүдэд бичилт хийж байгаа орлогын байцаагч нарын бичилт, барагдуулалтад тавих хяналтыг сайжруулах.

**Дээрх зөвлөмжүүдийг хэрэгжүүлж ажиллан, биелэлтийг 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн дотор албан тоотоор ирүүлнэ үү.**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Д.БАТ-УНДРАА